

НИЙСЛЭЛИЙН ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВ ИЛТГЭХ ХУУДАС

2024 оны 11 сарын 10 өдөр

Дугаар №6

Багануур дүүрэг

Ус намгийн нүүдлийн шувуудын идэвхтэй тандалт судалгаа

Нэг. Үндэслэл:

1.1. Шувууны томуу нь дэлхий нийтэд өргөн тархсан амьсгалын замын халдварт өвчин юм. Монгол оронд 2005, 2006 онд Хөвсгөл, Булган, 2009 онд Архангай, Хөвсгөл, 2010 онд Сүхбаатар аймагт зэрлэг шувуунд H5N1 хэвшлийн вирусээр үүсгэгдсэн өндөр хоруу чанарт шувууны томуугийн тохиолдол оношлогдож, ДМАЭМБ-ын Лавлагаа лабораториор баталгаажсан. Зэрлэг шувуудад дотоод, гадаадын мэргэжилтнүүдтэй хамтарсан судалгааг 2006 оноос хойш жил бүр гүйцэтгэж байгаа бөгөөд сул хоруу томуугийн вирус нь байнгын эргэлтэд байгаа нь тогтоогдсоор байна.

1.2. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдол: 2024 оны 11 сарын 05 наас 12 сарын 05 ны хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй

1.3. 2024 оны 11 сарын 05 наас 12 сарын 05 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H5N6, H3N8, H3N2, H7N9, H6N1, H10N8, H7N4, H5N8, H9N2 вирусийн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

Тохиолдол 1: АНУ улсын Орегон мужид шувууны аж ахуйд ойр ажилладаг ажилтан өндөр хоруу чанартай шувууны томуугийн H5 хэвшинжээр өвчилсөн. Тухайн бүс нутагт тэжээвэр шувуудын дунд өвчлөл бүртгэгдэж байсан ба өвчтөнд ханиадны анхны шинж тэмдэг илэрч эдгэсэн. <https://www.cdc.gov/bird-flu/spotlights/h5n1-response11152024.html> Тохиолдол 2: Канад улсын нийтийн эрүүл мэндийн газар 2024 оны 11 сарын 14 нд хүний өвчлөлийн 1 тохиолдол батлагдсан тухай мэдээлсэн. Халдварын эх уурхай одоогоор тодорхойгүй байгаа бөгөөд АНУ-д бүртгэгдсэн шувууны томуугийн дэд хэвшинжээс өөр буюу нүүдлийн шувуудаас илэрдэг хэвшинжтэй ижил байна. Хэв шинж, генийн дарааллыг тогтоох судалгаан дээр үндэслэж, шувууны томуугийн вирус хэрхэн хувьсан өөрчлөгдөж, хүний халдварын тохиолдол нэмэгдэх эрсдэлтэй байгаа тухай анхааруулсан.Canadian probe into teen's critical H5N1 infection finds no clear source | CIDRAP , www.nature.com Тохиолдол 3: Вьетнам улсын Лонган мужид өндөр хоруу H5N1 вирусийн хүний өвчлөлийн 1 тохиолдол бүртгэгдсэн тухай 12 сарын 04 нд мэдээлэв. Тухайн өвчтөний гэр бүлийн шувууны аж ахуйн шувууд олон тоогоор үхсэн боловч энэ тухай орон нутгын мэргэжлийн байгууллагад мэдээлээгүй байна.1.4. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн амьтдын мэдээлэл: 2024 оны 02 дугаар сарын 20-ноос 03 дугаар сарын 22-ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус АНУ, Алжир, Австри, Бразил, Болгар, Буркина Фасо, БНХАУ, Камбожи, Канад, Грек, Экватор, Франц, Дани, Герман, Хонг Конг, Унгар, Индонез, Изриаль, Итали, Япон, Мексик, Молдав, Норвеги, Польш, Румын, Словак, Швед, Украин Африк, Их Британи зэрэг 28 улс орны газар нутагт нүүдлийн болон тэжээвэр шувуудын дунд 120 тохиолдол бүртгэгдсэн.

1.5. Дэлхий дахинд нүүдлийн шувуудын үндсэн 8 зам байдгаас 3 гол зам нь Монгол орныг дайран өнгөрдөг нөхцөл нь манай оронд шувууны томуугийн өвчлөл гарах эрсдлийг үүсгэж байдаг.

Манай байгууллага нь 2006 оноос ус, намгийн шувуудын тоо толгой, зүйлийн бүрдлийг тогтоох судалгааг эхлэн 15 жилийн шувуу тооллогыг нэгтгэн дүгнэхэд Хэрлэн гол, түүний салаа хар ус, тогтоол жижиг нуур, бүрдүүдэд нүүдэллэн ирж зусдаг шувуудын 80 орчим хувийг галуутны багийн шувууд эзэлдэг, шувууны томуу вирус т мэдрэг өвчлөмтгий багийн шувууд бүртгэгдсэн.

Хоёр. Ажиглалт судалгаа хийсэн хугацаа:

2.1 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн 2024 оны 10 дугаар сарын 12-ны өдрийг дуустал 4 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Гурав. Тандалт судалгаа хийсэн бүрэлдэхүүн:

Халдвар судлагч эмч А.Мөнхтуул ахлан, Амьтан судлагч Б.Учрахбаяр, Шимэгч судлагч Б.Мөнгөнбагана, Хээрийн шинжилгээний жолооч М.Баярсайхан нар хамтран хийж гүйцэтгэлээ.

Дөрөв. Хийж гүйцэтгэсэн ажил:

3.1. Улаанбаатар хотын Багануур дүүрэг, Төв аймгийн Баяндэлгэр сумын нутагт орших Бага гүн, Их гүн, Аяга нуур, Бөөрөлжүүт, Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт Цагаан нуур хүртэл 350 км зам туулан ажиллалаа.

3.2. Цэгэн тооллогын аргаар судалгаанд хамрагдсан нууруудад Намрын тандалт судалгаагаар 5 нууран дээр 3 багийн 8 зүйлийн 725 шувуу тоолж бүртгэгдсэн. Тандалтын хугацаанд галуутны багийн нугасны овогт хамаарах 3 зүйл шувуу 100-аас дээш тоогоор тоологдож, нийт шувуудын 84,10% эзэлж байгаа нь томуу өвчинд өртөмтгий зүйлийн шувууд байна.

3.3. Махчин шувуудын ажиглалтыг замналын арга ашиглан талын сар 2, хээрийн бүргэд 3, нөмрөг тас 2, идлэг шонхор 2 тус тус тоолов.

3.4. Судалгаа хийсэн нуур орчмын мал бүхий айл, амралтын газруудаас хүн амын дундах асуумж судалгааг google form програм ашиглан авч байна



ХЯНАСАН:
ХАДВАР СУДЛАГЧ ЭМЧ

А.МӨНХТУУЛ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
ШИМЭГЧ СУДЛАГЧ

Б.МӨНГӨНБАГАНА

№	Явсан	Ирсэн	Явсан км	Зарцуулсан бензин /л/
1	Багануур дүүрэг	Багагүн нуур	24	3
2	Багагүн нуур	Их гүн нуур	19	2.4
3	Их гүн нуур	Аяга нуур	34	4.3
4	Аяга нуур	Бөөрөлжүүт	36	4.5
5	Бөөрөлжүүт	Баянжаргалан сум	38	4.8
6	Баянжаргалан сум	Цагаан нуур	76	9.6
7	Цагаан нуур	Багануур дүүрэг	133	16.8
Нийт			360	46.92